

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр

№ ХТ 01/2019

Улаанбаатар хот

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 12.00 цагаас 13.40 цагын хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Жуулчны гудамж 44, Арт хаус, 601 тоот, Эс Жи Капитал ҮЦК ХХК-ийн байранд хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 73.69/далан гурав зууны жаран ес/ хувь буюу 26'672/хорин зургаан мянга зургаан зуун далан хоёр/ ширхэг саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулав. Хэлэлцэх асуудал тус бүрээр “Санал асуултын хуудас”-ыг хувьцаа эзэмшигчдэд тараав. Түүнчлэн брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс ямар нэгэн хуралтай холбоотой баримт, материал ирээгүй болохыг танилцуулав. Хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөр талаар шийдвэр гаргав.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар 2019 оны ээлжит хурлын даргаар Б. Батхүүг сонгов.

Хурлыг нээж Б.Батхүү компанийн хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлуудыг нэг бүрчлэн дэлгэрэнгүй уншиж танилцуулж, холбогдох шийдвэрүүдийн төслийг мөн дэлгэрэнгүй байдлаар уншиж танилцуулав.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:


1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, батлах;
2. Компанийн 2018 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, батлах;

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу:

1. “Хар хорум пропертийс” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг танилцуулав. Холбогдох хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

2. Компани 2018 онд үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд үйл ажиллагааны тайланг танилцуулав. Холбогдох хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

2019 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



/ Б.БАТХҮҮ/

3. Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэж байгаа асуудлууд болон хурлын шийдвэрийн төслүүдэд ямар нэгэн санал өгөх, асууж тодруулах зүйл байгаа эсэхийг тодруулахад ямар нэгэн санал тодруулах зүйл гарсангүй.

4. Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдээс бөглөсөн саналын хуудсыг цуглуулан санал хураалтын дүнг нэгтгэв.

5. Тооллогын комиссоос санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцсэн асуудал тус бүрээр танилцуулж, санал өгсөн нийт тоо ширхэг, эсрэг саналтай болон түдгэлзсэн саналын талаар дэлгэрэнгүй танилцуулав. Үүнд: Хүчингүй болсон саналын хуудас, татгалзсан болон түдгэлзсэн саналын хуудас гараагүй. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хувьцаа эзэмшигчид хэлэлцсэн асуудал бүрийг дэмжиж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100/нэг зуу/ хувийн саналаар ЗӨВШӨӨРСӨН санал өгч тус компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг баталсан болохыг танилцуулав.

6. Хурлын тооллогын комиссоос “Тооллогын комиссын тогтоол”-уудыг нэг бүрчлэн уншиж танилцуулав.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр бүрийг хурлын дарга нэг бүрчлэн уншиж танилцуулав.

8. Хурлын дарга “Хар хорум пропертийс” ХК-ны ээлжит хурал үр дүнтэй, амжилттай болсоныг тэмдэглээд хурал хаасныг мэдэгдэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

/Б.БАТХҮҮ/


/Ж.БАЯРМАА/

/ЭКСПОНЭЙНШЛ ФАНД

МЕНЕЖМЕНТ ХХК/



2019 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТХҮҮ/